



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 01

Баруун-Урт сум

Сүхбаатар аймгийн Засаг даргын
2024-2028 оны үйл ажиллагааны
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Гуравдугаар Хурлаас ТОГТООХ нь:

1.Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөрийн хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Хөтөлбөрийн санхүүжилтийг жил бүрийн аймгийн төсөвт тусгаж, хэрэгжилтийн ханган, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (М.Идэрбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ХОСБАЯР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн
5 дугаар хуралдааны 01 тоот тогтоолын
нэгдүгээр хавсралт



**Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөр**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн ээлжит сонгуулийн үр дүнд улиран томилогдсон Засаг дарга нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, төрийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн саналд үндэслэн 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсрууллаа.

Бүс, орон нутагт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ил тод болгох, хүний эрхийг дээдэлсэн авлигагүй, эрүүл нийгмийг цогцлоох үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдийн нутагтаа сайхан амьдрах бүхий л боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

НЭГ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

1.1 . Иргэдийн ая тухтай амьдрах орчин, нөхцөлийг сайжруулна.

Бүсийн хөгжил

1.1.1. Бүсийн хамтын ажиллагааг сайжруулна.

1.1.1.1. Түүхэн аялал жуулчлал, эрчимжсэн хөдөө аж ахуйн суурь дэд бүтцийг байгуулна.

1.1.1.2. Бүсийн аймгуудтай хамтран ажиллана.

Аймгийн төвийн хөгжил

1.1.2. Дэд төв байгуулна.

1.1.2.1 Дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

1.1.2.2. Дэд төвийн инженерийн дэд бүтцийг байгуулна.

1.1.2.3. Нийгмийн үйлчилгээний барилга, байгууламжийн ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.1.2.4. Шинэ суурьшлын бүс байгуулна.

1.1.3. Аймгийн төвийн цахилгаан, дулаан, бохирын шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийг хийнэ.

1.1.3.1. Шинэ суурьшлын бүсүүдийг цахилгаан хангамжид холбоно.

1.1.3.2. Дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийг хийнэ.

1.1.4. Гэр хорооллыг дахин төлөвлөх замаар инженерийн дэд бүтэцтэй орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

1.1.4.1. 960 айлын орон сууцны хороолол төслийг эхлүүлнэ.

1.1.4.2. Амгалан гэр хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу амины орон сууц болон нийтийн орон сууцны төслийг эхлүүлнэ.

1.1.4.3. Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон сууцны хотхон хороолол барихыг бодлогоор дэмжинэ.

1.1.4.4. Шинээр баригдах дэд төвүүдтэй уялдуулан орон сууцны хорооллыг нэмж бий болгоно.

1.1.4.5. Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон, пассив барилгын стандартыг шаардлага хангасан бие даасан инженерийн шийдэлтэй хорооллыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн барьж байгуулахыг дэмжинэ.

1.1.5. Аймгийн төвийн авто замын сүлжээг өргөтгөнө.

1.1.5.1. Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам барих, их засвар шинэчлэлтийн ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.1.5.2. Аймгийн төвд нэгдсэн авто вокзал, терминал байгуулах ажлыг үе шаттай эхлүүлнэ.

1.1.6. Иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулна.

1.1.6.1. Хүн амын төвлөрөл ихтэй бүсэд байрлаж буй шатахуун түгээх станцуудыг нүүлгэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.1.6.2. Аймгийн төвийн нэгдсэн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлнэ.

1.1.6.3. Баруун-Урт сумын үерийн далангийн ажлыг үе шаттай хийнэ.

1.1.6.4. Аймгийн төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна.

1.1.7. Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулна

1.1.7.1 Сүхбаатар соёл амралтын хүрээлэнг өргөтгөн, тохижуулна.

1.1.7.2. Аймгийн төвийн цэцэрлэгт хүрээлэнгүүдийг тохижуулах, шинээр барих үйл ажиллагааг зохион байгуулна.

Сумдын хөгжил

1.1.8. Сумдын авто зам, тээврийн сүлжээг өргөтгөн хөгжүүлнэ.

1.1.8.1. Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажлыг үргэлжлүүлнэ.

1.1.8.2. Сумдын төвд хатуу хучилттай авто зам барина.

1.1.9. Сумдыг төвлөрсөн дулаан, ус, ариутгах татуургын нэгдсэн шугам сүлжээ, ариун цэврийн байгууламжийн хангамжтай болгож ашиглалтыг сайжруулна.

1.1.9.1. Сумдыг иж бүрэн инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн системд холбох ажлыг үе шаттай зохион байгуулна.

1.1.9.2 Сумдын төвлөрсөн ус, дулаан, ариутгах шугам сүлжээнд их засвар, өргөтгөлийн ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.1.9.3 Ус, дулаан үйлдвэрлэлийн ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

1.1.10 Сумдад орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

1.1.10.1. Төр хувийн хэвшлийн түншлэлээр сумдад орон сууц барих ажлыг дэмжинэ.

1.1.10.2. Сумдад төрийн албан хаагчийн орон сууц барих ажлыг бодлогоор дэмжинэ.

1.1.11. Сумдад эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.11.1. Сумдын дэд станцуудыг өргөтгөнө.

1.1.11.2. Сумдын шинээр төлөвлөсөн суурьшлын бүсүүдийг цахилгаан хангамжид холбоно.

1.1.11.3. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хамгаалалтын зурвас зөрчигдсөн цахилгаан дамжуулах шугамыг шинэчилнэ

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Хүн ам зүй

2.1. Гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

2.1.1.1. Хүүхдийн эрх, хамгааллыг сайжруулна.

2.1.1.2. Боловсролын байгууллагын орчин дахь хүүхэд хамгааллын нийгэм, сэтгэл зүйн орчныг сайжруулна.

2.1.2. Хүүхэд хөгжлийн үйлчилгээг өргөжүүлнэ.

2.1.2.1. Хүүхэд бүрд хөгжлийн үйлчилгээг хүргэнэ.

2.1.2.2. Бүс, улсын хэмжээний олимпиад уралдаан, тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна.

2.1.2.3. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг дэмжинэ.

2.1.3. Гэр бүлийг дэмжих үйлчилгээг нэмэгдүүлнэ.

2.1.3.1. Эцэг эх, асран хамгаалагч нарт чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ.

2.1.4. Залуучуудын хөгжил, нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.1.4.1. Залуучуудыг хамтдаа хөгжих, суралцахад дэмжлэг үзүүлнэ.

2.1.4.2. Залуучуудын гарааны бизнесийг дэмжинэ.

2.1.4.3. Өсвөр үе, залуучуудад зөөлөн ур чадвар олгоно.

2.1.5. Ахмад настны үйлчилгээг өргөжүүлнэ.

2.1.5.1. Ахмадын сувиллын үйл ажиллагааг тогтмолжуулж, өргөжүүлнэ.

2.1.5.2. Ахмад настны хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

2.1.5.3. Ахмад настны эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлнэ.

2.1.5.4. Ахмадын ордон, хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.1.6.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.1.6.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлт

2.2. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг дээшлүүлнэ.

2.2.1. Орон нутагт ажлын байрны тоог нэмэгдүүлнэ.

2.2.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.1.2. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажлын байр бий болгоно.

2.2.1.3. Ажил хайгч иргэдэд мэргэжил олгох, ур чадвар ахиулах сургалтыг зохион байгуулна.

2.2.1.4. Орон нутгийн онцлогт нийцүүлэн малжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.2.2. Зохист хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.2.2.1. Нийгмийн зөвшлийн харилцааг хөгжүүлнэ.

2.2.2.2. Ажлын байр олноор бий болгосон аж ахуй, нэгжийг урамшуулна.

Нийгмийн хамгаалал

2.3. Нийгмийн хамгааллын үйлчилгээний үр дүнг дээшлүүлнэ.

2.3.1. Нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.3.2.1. Сайн дурын даатгуулагчдын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.3.2.2. Ажил олгогч болон албан журмын даатгуулагчдын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.3.2.3. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд олон нийтэд түгээн сурталчлан, таниулна.

2.3.2.4. Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар хүргэнэ.

2.3.2. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ.

2.3.2.1. Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн өрхийн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулна.

2.3.2.2. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг иргэдэд хуулийн дагуу бүрэн олгоно.

Биеийн тамир, спорт

2.4. Биеийн тамир, спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.

2.4.1 Стандартын шаардлага хангасан биеийн тамир, спортын заал, талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

2.4.1.1. Спортын болон нийтийн биеийн тамирын стандартын шаардлага хангасан барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.

2.4.1.2. Спортын гадаа талбайг нэмэгдүүлж, стандартын шаардлагад нийцүүлнэ.

2.4.2 Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлнэ.

2.4.2.1. Сумдад нийтийн биеийн тамирын арга зүйч ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.4.2.2. Нийтийн биеийн тамир, спортын ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлнэ.

2.4.2.3 Ажлын байрны болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.

2.4.2.4. Нийтийг хамарсан спортын эвент арга хэмжээ зохион байгуулна.

2.4.3 Өсвөр үе, залуучуудын спортын авьяасыг нээн илрүүлэх, хөгжих боломжийг олгоно.

2.4.3.1. Өсвөрийн шигшээ багийг дэмжинэ.

2.4.3.2. Улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна.

2.4.3.3. Спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжинэ.

2.4.3.4. Спортын мэргэжлийн багш дасгалжуулагчдыг сургалтад хамруулна.

2.4.3.5. Биеийн тамир, спортыг дэмжих чиглэлээр хөрш орнуудтай хамтын ажиллагаа өрнүүлнэ.

Боловсрол

2.5. Сургалтын үнэлгээг ахиулна.

2.5.1. Боловсролын байгууллагын орчин, нөхцөлийг сайжруулна.

2.5.1.1. Стандартын шаардлага хангасан боловсролын байгууллагын тоог нэмэгдүүлнэ.

2.5.1.2. Боловсролын байгууллагыг сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангана.

2.5.1.3. Сургалтын байгууллагын бүтэц, тогтолцоонд шинэчлэл хийнэ.

2.5.2. Багшийн хөгжлийг дэмжинэ.

2.5.2.1. Багшийг гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлж, туршлага судлахад дэмжлэг үзүүлнэ.

2.5.2.2. Улс болон олон улсад амжилт үзүүлсэн, массын амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулна.

2.5.2.3. Багшийн зөөлөн ур чадварыг хөгжүүлнэ.

2.5.2.4. Багш нарын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.

2.5.3.Тэгш, хүртээмжтэй боловсролын үйлчилгээг хүргэнэ.

2.5.3.1. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

2.5.3.2. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулна.

2.5.3.3. Боловсролын байгууллагын хоол, хүнсний үйлчилгээг сайжруулна.

2.5.3.4. Орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэдлэг, ур чадвартай ажилтныг бэлтгэнэ.

2.5.4. Иргэдэд насан туршдаа суралцахуйн тэгш боломжийг бүрдүүлнэ.

2.5.4.1.Иргэдийн бие даан суралцах чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.5.4.2. Насан туршийн суралцахуйн нэгжийн орчин , нөхцөлийг сайжруулна.

2.5.4.3.Иргэдийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадварыг дээшлүүлнэ.

Эрүүл мэнд

2.6. Аймгийн хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ

2.6.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

2.6.1.1. Халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, тандалтыг нэмэгдүүлнэ.

2.6.1.2. "Эрүүл шүд", "Хорт хавдраас сэргийлэх, хянах", зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх "Эрүүл Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.

2.6.1.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд салбар дундын хамтын оролцоог хангана.

2.6.1.4. Архидан согтуурах, мансуурах болон дэлгэцэд донтох өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүний хор уршигтай тэмцэхэд чиглэсэн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлнэ.

2.6.2. Эрүүл мэндийн байгууллагуудад үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлнэ

2.6.2.1. Стандартын шаардлага хангасан эрүүл мэндийн салбарын барилга, байгууламжийг нэмэгдүүлнэ.

2.6.2.2. Яаралтай түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийнэ.

2.6.2.3. Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ.

2.6.3.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

2.6.3.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлнэ.

2.6.3.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.

2.6.3.3 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн чадавхыг дээшлүүлнэ.

2.6.3.4. Иргэдэд үзүүлэх төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.6.3.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангана.

2.6.3.6. Эрүүл мэндийн салбарт цахим программ, платформын ашиглалтыг сайжруулна.

2.6.2.7. Яаралтай тусламжийн чадавхыг нэмэгдүүлнэ.

2.6.3.8. Дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

2.6.3.9.Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжиж, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

2.6.3.10. Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжинэ.

2.6.3.11. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлж эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

**Барилгын материалын
үйлдвэрлэл, газар зохион байгуулалт**

2.7. Барилгын материалын үйлдвэрлэл, газар зохион байгуулалтыг сайжруулна.

2.7.1. Орон нутгийн барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

2.7.1.1. Барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй, эко бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.7.1.2. Барилгын материалын лабораторийг ашиглалтад оруулна.

2.7.2. Газар зохион байгуулалтыг сайжруулна.

2.7.2.1. Дэд бүтцийн хангамжид тулгуурлан иргэдэд газар өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тогтоож газрыг өмчлүүлнэ.

2.7.3.2. Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

2.7.3.3. Төв, суурин, бэлчээр, тариалангийн газарт газрын төлөв, байдал, чанарын улсын хянан баталгаажуулалт хийлгэнэ.

2.7.3. Аймаг, сумдын төвийн хүн амыг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан ундны усаар хангана.

2.7.3.1. Нийтийн орон сууцуудын дундын өмчлөлийн цэвэр, бохир усны хуучирсан шугам сүлжээг шинэчилнэ.

2.7.3.2. Төв, суурин газрын хүн амын ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

2.7.3.3. Зөөврийн ус түгээх цэгүүдийг төвлөрсөн шугамд холбоно.

2.7.3.4. Сумдын ундны эх үүсвэрт цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулж, шинэчилнэ.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Төсөв, санхүү

3.1. Үр дүнд суурилсан төсөвлөлтийн чиг хандлагад нийцүүлсэн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Төсвийг үр дүнд суурилсан зарчмаар төлөвлөж, хуваарилна.

3.1.1.1. Төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомж, бодит судалгаа, шинжилгээнд үндэслэн бүрэн төлөвлөж, төвлөрүүлнэ.

3.1.1.2. Төсвийн зарцуулалтын хэмнэлттэй, үр дүнтэй, ил тод байдлыг хангана.

3.1.1.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулна.

3.1.1.4. Төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.1.5. Орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

3.1.2. Статистикийн мэдээллийн чанарыг сайжруулна.

3.1.2.1. Статистикийн мэдээ, тайланг цуглуулах явцад хяналт хийнэ.

3.1.2.2. Улсын хэмжээний ээлжит тооллого зохион байгуулна.

Төрөлжсөн эдийн засаг

Уул уурхай

3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхайг дэмжин хөгжүүлнэ.

3.2.1. Ашигт малтмалын ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

3.2.1.1. Уул уурхайн нөхөн сэргээлтийг хуулийн хүрээнд гүйцэтгүүлнэ.

3.2.1.2. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн тусгай зориулалтын авто зам барих ажлыг эхлүүлнэ.

3.2.1.3. Уул уурхайн хайгуул, ашиглалтын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

3.2.2. Эрдэс баялгийн салбарын үйл ажиллагаанаас орон нутгийн хөгжилд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.2.2.1. Нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, иргэдийн ойлголцол, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.2.2.2. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих уул уурхайн боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн барилга байгууламжийн төслүүдийг дэмжиж ажиллана.

Боомтын шинэчлэл, тээвэр, логистик

3.3. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээврийн сүлжээг өргөтгөн хөгжүүлнэ.

3.3.1. Бүсийн хөгжлийг дэмжих олон улс, улсын чанартай зам тээврийн сүлжээг өргөтгөнө.

3.3.1.1. Эрээнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина.

3.3.1.2. Баруун-Урт-Бичигт боомт чиглэлийн 180 км хатуу хучилттай авто зам барина.

3.3.1.3. Баруун-Урт-Халзан-Онгон сум, Дарьганга - Бичигтийн боомтын төв зам чиглэлийн хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлнэ.

3.3.2. Бичигт боомтын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

3.3.2.1. Бичигт боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.

Эрчим хүч

3.4. Эрчим хүчний найдвартай байдлыг хангана.

3.4.1. Эрчим хүчний эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.4.1.1. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих дулааны цахилгаан станц барих ажлыг дэмжинэ.

3.4.1.2. Дулааны станцыг өргөтгөх ажлыг үргэлжлүүлж, ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.

3.4.1.3. Цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн өргөтгөл хийхийг дэмжинэ.

Мэдээлэл, харилцаа холбоо, инновац

3.5. Харилцаа холбооны дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.5.1. Харилцаа холбооны хэрэглэгчийн тоог нэмэгдүүлнэ.

3.5.1.1. Хөдөөгийн алслагдсан багуудад харилцааны холбооны сүлжээ нэвтрүүлнэ.

3.5.1.2. Харилцаа холбооны шугам сүлжээг хот төлөвлөлтийн дагуу өргөтгөнө.

3.5.1.3. 5G технологийг нэвтрүүлэх ажлыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулна.

МАЛ АЖ АХУЙ

3.6. Малын чанарыг сайжруулна.

3.6.1. Өндөр ашиг шимт малын тоог нэмэгдүүлнэ

3.6.1.1. Үржлийн малын 3-аас доошгүй хувьд үзлэг ангилалт хийнэ

3.6.1.2. Нийт мал сүрэгт цөм сүргийн малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ

3.6.1.3. Стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч малын тоо толгойг нэмэгдүүлнэ

3.6.1.4. Гойд ашиг шимт малыг улс, аймгийн хэмжээнд сурталчлан таниулна

3.6.1.5. Биотехнологийн дэвшилтэд аргаар малд зохиомол хээлтүүлэг хийнэ

3.6.1.6. Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид дэмжлэг үзүүлнэ.

3.6.1.7. Мал аж ахуй эрхлэгчдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлнэ.

3.6.1.8. Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлнэ.

3.6.1.9. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ.

3.6.2. Малын эрүүл мэндийг хамгаална

3.6.2.1. Мал, амьтны өвчинтэй тэмцэж, урьдчилан сэргийлнэ

3.6.2.2. Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлгийн магадлан шинжилгээ хийж хянан баталгаажуулна

3.6.2.3. Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн ажлыг үе шаттай зохион байгуулна

3.6.2.4. Сум дундын мал эмнэлэг, ариун цэврийн анхан шатны лаборатори байгуулна

3.6.2.5. Малын эрүүл бүсийг байгуулна

3.6.3. Бэлчээр ашиглалтыг сайжруулна

- 3.6.3.1. Бэлчээрийн сэлгэн ашиглалтыг нэмэгдүүлнэ
- 3.6.3.2. Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэнэ.
- 3.6.3.3. Хадлангийн талбайг хашиж, хамгаална.
- 3.6.3.4. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ

ГАЗАР ТАРИАЛАН

3.7. Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ

3.7.1. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ

- 3.7.1.1. Хүлэмжийн ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ
- 3.7.1.2. Зоорины аж ахуйг дэмжинэ.
- 3.7.1.3. Жимс, жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлнэ

3.7.2. Үр тарианы тариалалтыг нэмэгдүүлнэ

- 3.7.2.1. Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг хангах зорилгоор "Атар IV" аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн нийт эргэлтийн талбайг нэмэгдүүлнэ
- 3.7.2.2. Газар тариалан эрхлэгчдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлнэ
- 3.7.2.3. Хөдөө аж, ахуйн зайлшгүй шаардлагатай тоног, төхөөрөмжийн нийлүүлэлтийг бодлогоор дэмжинэ.

Хүнс, хөнгөн үйлдвэрлэл

3.8. Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.

3.8.1. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг эрчимжүүлнэ.

- 3.8.1.1. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодыг чадавхжуулах үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ
- 3.8.1.2. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоог бүсчлэн байгуулна.
- 3.8.1.3. Хоршоодод хөрөнгө, санхүүгийн дэмжлэг олгоно

3.8.2. Боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

- 3.8.2.1. Орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандарт, борлуулалтыг нэмэгдүүлнэ
- 3.8.2.2. Үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.
- 3.8.2.3. Орон нутагт сүү боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулна.
- 3.8.2.4. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 3.8.2.5. Бизнес эрхлэгчдийн хүний нөөцийг чадавхжуулж, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулна.

3.8.3. Худалдаа, үйлчилгээний эрхлэгч аж ахуй нэгжүүдийн чанар, стандартын хэрэгжилтийг сайжруулна.

- 3.8.3.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгжүүдийн стандартыг сайжруулна.
- 3.8.3.2. Үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварыг нэмэгдүүлнэ.

3.8.4. Хүнсний аюулгүйн байдал, чанарыг сайжруулна.

- 3.8.4.1. Зарим нэр төрлийн бүтээгдэхүүний орон нутгийн хангамж, нөөцийг нэмэгдүүлнэ.

3.8.4.2. Хүнсний эрүүл ахуй, чанарын хяналтыг сайжруулна.

Соёл, урлаг

3.9. Соёл урлагийн үйлчилгээний чанарыг сайжруулна.

3.9.1. Соёл, урлагийн байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулна.

3.9.1.1. Стандартын шаардлага хангасан соёлын байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.

3.9.1.2. Соёл, урлагийн байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

3.9.2. Соёл урлагийн салбарын мэргэжлийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ.

3.9.2.1 Соёл, урлагийн салбарын албан хаагчдыг гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, туршлага судлуулна.

3.9.2.2 Улс, олон улсын уралдаанд өндөр амжилт үзүүлсэн албан хаагчдад урамшуулал олгоно.

3.9.2.3. Соёл, урлагийн салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг дэмжинэ.

3.9.3. Соёл урлагийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.9.3.1. Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлнэ.

3.9.3.2. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.9.3.3. Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

3.9.3.4. Орон нутгийн онцлогийг илтгэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.9.3.5. Үндэсний хэл бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

3.9.3.6. Угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлнэ.

Аялал жуулчлал

3.10. Жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

3.10.1. Орон нутгийн аялал жуулчлалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.10.1.1 Нутгийн иргэдэд түшиглэн нүүдлийн соёлыг харуулсан эвент арга хэмжээг нэмэгдүүлнэ.

3.10.1.2. Өвлийн аялал жуулчлалыг үе шаттай хөгжүүлнэ

3.10.1.3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлнэ.

3.10.1.4. Аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

3.10.1.5. Орон нутгийн аялал жуулчлалын сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

3.10.1.6. Аялал жуулчлалын салбарт хүний нөөцийг бэлтгэж, давтан сургах, чадавхжуулах ажлыг зохион байгуулна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт

3.11. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг сайжруулна.

3.11.1. Агаар, хөрсний бохирдлоос сэргийлнэ.

3.11.1.1. Агаарын бохирдлын хэмжилт судалгааны чадавхыг сайжруулна.

3.11.1.2. Аймгийн хэмжээнд ашиглаж байгаа хөрс бохирдуулагч нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ

3.11.1.3 Хог хаягдал, эко ариун цэврийн байгууламжийн талаарх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.

3.11.1.4. Хог хаягдлыг ангилан ялгадаг савны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.11.1.5. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжинэ.

3.11.1.6. Сумдын төвлөрсөн хогийг цэгийг стандартын шаардлагад нийцүүлнэ.

3.11.1.7. Аюултай хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй аргаар хадгалж тушаах, устгах ажлыг зохион байгуулна.

3.11.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулна.

3.11.2.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.11.3. Усыг бохирдож, хомсдохоос хамгаална.

3.11.3.1. Усны үрэлгэн хэрэглээг багасгахад чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулна.

3.11.3.2. Үйлдвэрлэлийн хаягдал усыг дахин ашиглана.

3.11.3.3. Хөрсний ус ашиглаж хөв цөөрөм байгуулна.

3.11.3.4. Нөлөөлөлд өртөж буй булаг шандын эх, нуурыг хашиж хамгаална.

3.11.3.5. Зөвшөөрөлгүй худгуудыг паспортжуулна.

3.11.4. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

3.11.4.1. Бүх нийтээр мод тарьж, ургуулахад чиглэсэн аян, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.

3.11.4.2. Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

3.11.4.3. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.11.4.4. Ой, ногоон байгууламжийн чиглэлээр боловсон хүчнийг бэлтгэж, чадавхжуулна.

3.11.4.5. Мод ургуулахад шаардлагатай техник технологи, материаллаг баазыг бэхжүүлнэ.

3.11.4.6. Үр, тарьц суулгацын нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

3.11.4.7. Аймаг, сумдад мод тарих газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөг жил бүр баталж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

3.11.5. Биологийн олон янз байдлын нөөцийг хамгаална.

3.11.5.1. Амьтны тархац нутгийг хамгаалж, нүүдлийн замыг чөлөөтэй байлгана.

3.11.5.2. Ан амьтанд биотехникийн арга хэмжээг зохион байгуулна.

3.11.5.3. Ашиглалтад өртөмтгий амьтныг сэргээн нутагшуулж хамгаална.

3.11.5.4. Цөлжилттэй тэмцэж ургамлан бүрхэвчийг нэмэгдүүлнэ.

3.11.6. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.11.6.1. "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах төлөвлөгөө"-г баталж, хэрэгжүүлнэ.

3.11.6.2. Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт технологиудыг иргэдэд таниулах мэдээллийн төв байгуулна.

3.11.6.3. Эрчим хүчний хэмнэлттэй болон сэргээгдэх эрчим хүчний үүсвэрээс хэрэглэгчдийг цахилгаан, дулаанаар хангах боломжийг судалж, хэрэгжүүлнэ.

3.11.6.4. Цаг агаарын гамшигт болон аюулт үзэгдлийн мэдээллийн чанарыг сайжруулна.

3.11.6.5. Эрчим хүчний хэмнэлт бий болгох дулаалгын төслийг хэрэгжүүлнэ.

3.11.6.6. Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийг пассив барилгын стандартад нийцүүлж, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх арга хэмжээ авна.

ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Хууль, эрх зүй

4.1. Хүний эрхийн зөрчлийг бууруулна.

4.1.1. Хүний эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлнэ.

4.1.1.1. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.

4.1.1.2. Өмгөөллийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.1.2. Гэмт хэрэг, зөрчлийг бууруулна.

4.1.2.1. "Ногоон бүс" төслийг үргэлжлүүлж, сумдыг хяналтын камерын нэгдсэн системд холбоно.

4.1.2.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

4.1.2.3. Хууль зүйн салбарын агентлаг, байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.1.2.4. Аймгийн төвийн цэвэр усны эх үүсвэрийг дотоодын цэргийн хамгаалалтад авна.

4.1.3. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

4.1.3.1. Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

4.1.3.2. Хилийн цэргийн ангиудын хангалт үйлчилгээнд туслалцаа үзүүлнэ.

Төрийн алба:

4.2.Төрийн үйлчилгээний үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

4.2.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.2.1.1. Нутгийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоог оновчтой тодорхойлж, мөрдүүлнэ.

4.2.1.2. Төрийн албаны салбар дундын уялдаа холбоог сайжруулна.

4.2.1.3. Нутгийн захиргааны байгууллагын орчин нөхцөлийг сайжруулна.

4.2.2. Төрийн албаны хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлнэ.

4.2.2.1. Хүний нөөцийн суурь судалгаанд үндэслэн орон нутагт эрэлттэй мэргэжилтнийг үе шаттай бэлтгэнэ.

4.2.2.2. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.

4.2.3. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг сайжруулна.

4.2.3.1. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлнэ.

4.2.3.2. Төрийн албаны хүний нөөцийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулна.

4.2.3.3. Төрийн албан хаагчдыг гадаад, дотоодод туршлага судлуулж, сургана.

4.2.4. Төрийн цахим шилжилтийг эрчимжүүлнэ.

4.2.4.1. Төрийн байгууллагуудын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангана.

4.2.4.2. Төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлнэ.

4.2.4.3. Иргэдийн цахим ур чадварын түвшнийг дээшлүүлнэ.

4.2.4.4. Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулна.

4.2.5. Авлигыг үл тэвчих соёл, хандлагыг нэмэгдүүлнэ.

4.2.5.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг үр дүнтэй зохион байгуулна.

4.2.5.2. Авлига, ашиг сонирхлын зөрчилд хариуцлага тооцох, эрх бүхий этгээдийн шаардлага, зөвлөмж, мэдэгдлийг хэрэгжүүлнэ.

4.2.6. Үр дүнд суурилсан үнэлгээ, мониторингийн чадавхыг бэхжүүлнэ.

4.2.6.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, мониторинг хийх журмыг орон нутгийн онцлогт нийцүүлэн боловсруулж, мөрдөнө.

4.2.6.2. Үнэлгээ, мониторингийн чадавхыг бэхжүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна.

4.2.6.3. Үнэлгээ, мониторингийн үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллага, хөндлөнгийн байгууллагын оролцоог хангана

4.2.6.4. Гүйцэтгэлийн удирдлага, үнэлгээ, мониторингийн нэгдсэн системийг нутгийн захиргааны байгууллагуудад нэвтрүүлнэ.

4.2.7 Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн зохион байгуулалтыг сайжруулна.

4.2.7.1. Төрийн архивд хадгалагдаж байгаа сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангана.

4.2.7.2. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлнэ.

Гадаад харилцаа

4.3. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.3.2. Хөрш орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.3.2.1. БНХАУ-ын аймаг, хотуудтай хийх хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.3.2.2. ОХУ-ын хил орчмын муж хотуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

4.3.2. Гуравдагч хөрш орнуудтай хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

4.3.2.1. Гуравдагч хөрш орнуудын муж, хоттой харилцаа тогтооно.

4.3.2.2. Элчин сайдын яам, консулын газартай хамтран ажиллана.

4.3.2.3. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа

4.4. Гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлнэ.

4.4.1. Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх дадалтай иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

4.4.1.1. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй хүргэнэ.

4.4.1.2. Гамшгаас хамгаалах ангиллын иргэдийн сургалт зохион байгуулна.

4.4.2. Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах бэлэн байдлыг хангана.

4.4.2.1. Гамшгаас хамгаалах тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, шинэчилнэ.

4.4.2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

- 4.4.2.3. Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, иж бүрэн болон команд штабын сургууль, дадлагыг зохион байгуулна.
- 4.4.2.4. Орон нутагт гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэнэ.

Батлан хамгаалах үйл ажиллагаа

4.5. Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.

4.5. 1. Иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлнэ.

4.5.1.1. Хүүхэд залуучуудад цэрэг, эх оронч үзлийг таниулна.

4.5.1.2. Батлан хамгаалах үйл хэргийг иргэд сурталчилна.

4.5.2. Зэвсэгт хүчний анги, салбарын бэлэн байдлыг хангана.

4.5.2.1. Томилгоот бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах, сурган дадлагажуулна.

4.5.2.2. Зэвсэгт хүчний анги, салбарын материаллаг баазыг сайжруулна.

4.5.2.3. Цэргийн тоо бүртгэл, цэрэг халах, татах ажиллагааг зохион байгуулна.

4.5.2.4. Цэргийн насны залуучуудыг эдгээн эрүүлжүүлнэ.

---oOo---